

ӨМНӨХ ҮГ

Монголын Хүн Ам ба Хөгжил Нийгэмлэг, Хүн Амын Сургалт Судалгааны Төвтэй хамтран НҮБ-ын Хүн Амын Сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр «Монголын Хүн Амын Сэтгүүл»-ийн 15 дахь дугаарыг Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуулийн 60 жилийн ойд зориулан бэлтгэж, эрхэм уншигч та бүхэнд толилуулж байна.

Сэтгүүлийн «Судалгаа» хэсгээс Улаанбаатар хотын төвийн дүүргүүдийн хүн амын хэтийн тооцоо 2005-2020, Монгол хүний тэтгэврийн насны судалгаа, прогноз зэрэг хүн амын шилжилт хөдөлгөөн, нийгмийн бүлгүүдийн шийдвэрлэвэл зохих асуудлыг хөндсөн сонирхолтой судалгааны ажлуудтай танилцаах болно.

Харин «Сургалт» хэсгээс бидний өдөр тутмын амьдрал болон бизнесийн үйл ажиллагаанд хэрэгцээтэй Компьютерийн гэмт хөргээс үүдэлтэй эрсдэл, түүнээс сэргийлэх арга замууд, Лизингээр эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх боломжуудын талаар сонирхолтой материалуудтай танилцаарай.

Түүнчлэн, «Үзэл бодол» хэсгээс та Дэлхийн хүний хөгжлийн илтгэл, үүсэл хөгжлийн талаар судлаачийн хийсэн харьцуулалт, санал бодлыг уншиж өөрийн эргэцүүллийг хийх боломжтой.

Сэтгүүлийн English булан Cost-Benefit Analysis of In-Migration to Ulaanbaatar city, Determinants of Asian Fertility Decline гэсэн сэдэвтэй Улаанбаатар хотыг чиглэсэн шилжих хөдөлгөөний өртөг болон Азийн улс орнуудын төрөлтийн бууралтыг тодорхойлогчдын талаар эрдэмтэдийн хийсэн судалгаа, шинжилгээний ажилтай танилцуулж байна.

Сэтгүүлийн энэ удаагийн дугаарт нийтлэгдэж буй судалгаа, шинжилгээний ажлууд, эрдэмтэн, судлаачдын үзэл бодлын талаар уншигч та шүүмж, мэтгэлцээн, хэлэлцүүлэг орнуулэн, манай дараагийн дугаарт өөрийн материалыа ирүүлийн гэдэгт бид итгэлтэй байна.

Эцэст нь, Монгол улсын хүн ам, хөгжлийн асуудлаар эрдэм шинжилгээ, судалгааны ажилд оюун ухаан, мэдлэг чадвараа зориулж буй нийт эрдэмтэн судлаачид, мэргэжилтэн, оюутан, залуучууд та бүхэндээ болон сэтгүүлийн дугааруудыг бэлтгэн хэвлэхэд байнгын дэмжлэг, туслалцаа үзүүлж байгаа НҮБ-ын Хүн Амын Сангийн Суурин Төлөөлөгчийн Газарт сэтгүүлийн редакцийн нэрийн өмнөөс гүн талархлаа илэрхийлье.

Эрхэм уншигч таны оюуны мэлмий тань тэлэх болтугай.

РЕДАКЦИЙН ЗӨВЛӨЛ